

Уур амьсгалын оорчлолтийг зоолрvvлэх хvчин зvйлvvдийн олон улсын нэрсийн жагсаалтад бэлчээрийг хамгаалан сайжруулах ажил орсон богоод бэлчээрийн хорс нvvрсторогчийн хуримтлалыг нэмэгдvvлэх асар их чадавхтайг онцлон дурдсан байдаг. Монголын Бэлчээрийн менежментийн холбоо (МБМХ) уур амьсгалын оорчлолтийг зоолрvvлэх, тvvнд дасан зохицох асуудлыг олон улсын тvвшинд хвлээн зовшоорч буйг ойлгон ухамсарлаж, бэлчээрийн болон мал аж ахуйн менежментийг боловсронгуй болгох замаар хорсон дэх нvvрсторогчийн хуримтлалыг нэмэгдvvлэн нvvрсторогчийн сайн дурын зах зээлд борлуулах асар их бололцоог ашиглахаар зорьж байна.

Yвнтэй уялдуулан манай Холбоо 2010 онд хорсонд нvvрсторогчийг хуримтлуулж зах зээлд борлуулах тослийг Овор Монголд хэрэгжvvлж байгаа Андреас Вилкес, Тимм Теннигкеит нартай холбоо тогтоон Монгол улсад ийм чиглэлийн тосол хэрэгжvvлэх санал тавьсан юм. Энэ саналыг Швейцарийн Хогжлийн Агентлаг дэмжин санхvvжvvлж, дээрх хоёр мэргэжилтэнг МБМХ –ны шугамаар Монголд урин ирvvлж, Ногоон алт тослийг хэрэгжvvлж байгаа, ялангуяа Бэлчээр ашиглалтын хэсгийн (БАХ) системийг нэвтрvvлж байгаа сумдаар оруулан нохцол байдалтай танилцуулж, баримжаа судалгааг хийлгэсэн болно.

Ийм судалгааны дvнд БАХ-ийн хvрээнд хэрэгжvvлж байгаа доройтсон бэлчээрийг сэлгэх, онжоож амраах, хадлан бэлтгэх, хаягдсан тариалангийн талбайн ургамлан номрогийг нохон сэргээх, отрын нооц бэлчээр гаргах, мод, бут соог, тэжээлийн олон наст ургамал тариалах зэрэг вйл ажиллагааг явуулснаар бэлчээрийн бvтээмжийг дээшлvvлж болохыг нотолсон юм. Энэ судалгаанд хамрагдсан гурван сумын 580 мянган га бэлчээр нь жилд 180 мянган т СО₂ (нvvрсхvчлийн хийг) агаараас хорсонд шингээн хуримтлуулах боломжтой гэсэн урьдчилсан тооцоог гаргав. Энэ нь уур амьсгалын оорчлолтийг сааруулах, дулаарлыг бууруулах асар их боломж Монгол улсад байгааг харуулж байгаа юм. Мал сvргийн ашиг шимийг нэмэгдvvлэх, бvтээгдэхvн борлуулалтыг сайжруулах зэрэг бусад вйл ажиллагаатай хослуулан хорсонд хуримтлагдах нvvрсторогчийн хэмжээг нэмэгдvvлэн зах зээлд борлуулбал малчдын аж амьдралыг дээшлvvлэх, тэдний уур амьсгалын оорчлолтод дасан зохицох чадавхыг нь сайжруулахад влэмж ач холбогдолтой болно.

Олон улсын хэмжээнд авч взвэл ийм чиглэлийн тосол боловсруулсан тал агаараас хорсонд шингээсэн СО₂-ийн нэг т тутамд 2-8 ам доллар (жигжиглэнгийн зах зээлд 12-30 ам доллар) олдог байна.

Дээр дурдсан судалгааг vргэлжлvvлэн БАХ-ийн системд тулгуурласан **“Малчдыг нvvрстөрөгчийн зах зээлтэй холбох нь”**

гэсэн нарийвчилсан судалгааны хоёр жилийн (2011-2012 он) тослийг хэрэгжvvлж эхлээд байна. ШХА энэ тослийг 800 мянган швейцарь франкаар санхvvжvvлж байгаа юм. Тослийн vндсэн хэрэгжvvлэгч нь Герман дахь “Unique forestry consultants GmbH”.

Уг тосол:

(1) Нvvрстөрөгчийн санхvvжилтийн дэмжлэгтэйгээр бэлчээрийн тогтвортой менежментийг төлөвшvvлэх үүднээс Монголын оролцогч талуудын хэрэглэж болох, нvvрстөрөгчийн олон улсын зах зээлийн шаардлагад нийцсэн аргуудыг боловсруулах,

(2) Уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий бус бэлчээрийн менежментийн ухаалаг бодлогын хувилбарыг боловсруулахад нь бодлого боловсруулагчдад туслах гэсэн үндсэн хоёр бүтээгдэхvvн гаргах юм.

2011 оны 1 дvгээр сараас 2012 оны 12 дугаар сард буюу хоёр жилийн хугацаанд доорх үр дvнг гаргана. Үүнд:

1. Оролцогч талууд харилцан зовшоорсон, тэдний ашиг сонирхолд нийцсэн Тосол хэрэгжvvлэх хамгийн боломжтой сумыг сонгоно,
2. Хvлэмжийн хийн ялгарлын бууралтыг үнэлэх аргуудыг боловсруулна,
3. Эдийн засгийн үр огоож огохvйц мал аж ахуйн бүтээгдэхvvн вйлдвэрлэх, бүтээгдэхvvн борлуулах хувилбарыг боловсруулна.
4. Эрсдэл болон нийгэмд үзvvлэх сорог нолоо бага байхаар тослийг боловсруулна,
5. Тосол боловсруулах баримт бичгийг батлуулсны үндсэн дээр Хийн ялгарлын бууралтыг худалдах Гэрээнд гарын үсэг зуруулна,
6. Уур амьсгалын оорчлолтод ортомтгий бус бэлчээрийн менежментийн ухаалаг бодлогын хувилбаруудыг шинжилж, бодлого боловсруулагчдад тусална.

Эдгээр дvнг сайн дурын зах зээл дээр нvvрстөрөгчийн хуримтлалыг санхvvжvvлэх бүртгэлд бүртгvvлэхэд шаардлагатай гол гол баримт бичгийн дагуу томъёолсон байна. Эдгээр үр дvнг гаргахдаа чанар сайтай хавсрага судалгааг явуулж, олон улсын мэргэжилтнvvдийн зовлогоог авах юм. Энэ тослийн эцэст Бэлчээрийн хорсний нvvрстөрөгчийн хуримтлалыг санхvvжvvлэх урт хугацааны Тослийн бэлтгэлийг хангана.

Одоогийн байдлаар Монголд тусдаа байгуулагдсан Тосол хэрэгжvvлэх нэгжийн тоолоогооний дагуу МБМХ-ны мэргэжилтэн, судлаачид сум сонгох шалгуурын дагуу гурван сумын хорс, ургамалжилт, мал аж ахуй, нийгэм, эдийн засгийн байдлыг харьцуулан судалж, Архангай аймгийн Тариат сумыг сонгохоор санал боловсруулаад байна. Ер нь энэ тослийн бэлтгэл судалгааны ажилд АХБ, Швейцарийн Ходоо аж ахуйн коллеж, Монголын холбогдох байгууллагын эрдэмтэд хамтран оролцох юм.